



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зооноз ӨСТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэбулган хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn  
Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг  
Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АД26-Од-25 № 111  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН Г  
ТӨВИЙН ДАРГА Д.БЯМБАСҮРЭН  
ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд

- Нийгмийн даатгалын газарт 3,317.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн, цалингаас суутгасан 8,070.5 мянган төгрөгийн ашгийн татварыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй,
- НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын болон бусад материалыг зөв ангилан бүртгээгүй
- Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн дахин үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, хөрөнгийн ангилан бүртгэлт хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалтуудыг

зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 254,811.9 мянган төгрөгийн өртөгтэй барилга, 29,736.5 мянган төгрөгийн өртөгтэй пургон авто машин, 32 нэр төрлийн 45,458.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 62,684.3 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлж үнэ төлбөргүй орлогоор авсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Зоонозын өвчин судлалын төв нь улсын төсвийн санхүүжилтээр 793,895.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 1,140.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч төсөвт 5,930.5 мянган төгрөг төсөвт буцаан төвлөрүүлж харилцах дансны үлдэгдэлгүй байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 3 нэр төрлийн 11,974.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан. Тайланд онд халдварт өвчний шинжтэй 46 дуудлага хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлж хариу арга хэмжээ авч ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 89.3 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>129,217,866.14</b>	<b>162,395,619.31</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>250,500.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	250,500.00
3351	Байгууллагаас авах авлага	-	250,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>129,217,866.14</b>	<b>162,145,119.31</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	112,610,255.14	146,248,998.31
35130	Эм боох материал	112,610,255.14	146,248,998.31
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	16,607,611.00	15,896,121.00
35410	Бичиг хэргийн материал	1,565,370.00	635,000.00
35420	Аж ахуйн материал	11,598,941.00	10,235,621.00
35440	Түлш, шатах тослох материал	2,864,600.00	3,075,000.00
35450	Барилгын засварын материал	578,700.00	1,950,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>472,807,344.82</b>	<b>455,576,699.09</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	472,807,344.82	455,576,699.09
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	347,527,344.82	330,296,699.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	256,649,280.90	21,837,380.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(255,037,080.00)	(262,710.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,819,554.00	77,878,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,079,553.84)	(40,927,999.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	400,517,874.15	397,827,956.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,541,210.36)	(131,937,975.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,589,356.00	3,407,996.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,113,209.37)	(1,114,449.09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,288,000.00	10,590,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,565,666.66)	(7,001,499.92)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	125,280,000.00	125,280,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	125,280,000.00	125,280,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>602,025,210.96</b>	<b>617,972,318.40</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>503,800.00</b>	<b>947,870.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	503,800.00	947,870.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	503,800.00	947,870.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	503,800.00	947,870.00
41361	Байгууллагад төлөх өглөг	503,800.00	947,870.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>601,521,410.96</b>	<b>617,024,448.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	601,521,410.96	616,773,948.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	240,575,168.00	240,575,168.00
51101	Өмч: - төрийн	240,575,168.00	240,575,168.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	358,981,112.71	374,392,960.30
51210	Өмнөх үеийн үр дүн	358,981,112.71	359,140,422.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	15,252,537.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,965,130.25	1,805,820.10

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>602,025,210.96</b>	<b>617,972,318.40</b>
---	--	-----------------------	-----------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>957,293,094.99</b>	<b>886,200,772.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>257,201,494.99</b>	<b>91,215,072.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	257,201,494.99	91,215,072.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	91,215,072.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	62,684,282.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	28,530,790.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,091,600.00</b>	<b>793,845,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	700,091,600.00	793,845,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	700,091,600.00	793,845,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	1,140,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,140,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>841,547,594.03</b>	<b>870,948,234.56</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>841,547,594.03</b>	<b>870,948,234.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	841,547,594.03	791,033,306.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	551,943,435.70	640,900,499.97
210101	Үндсэн цалин	330,133,359.18	346,352,009.79
210102	Нэмэгдэл	146,647,958.27	221,137,937.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,317,959.65	28,962,000.00
210104	Урамшуулал	42,844,158.60	44,448,552.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,332,100.00	83,138,000.00
210201	Тэтгэврийн даатгал	58,868,800.00	54,668,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,197,200.00	6,432,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,763,600.00	6,221,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,776,000.00	3,136,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,726,500.00	12,679,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,092,662.00	20,787,037.00
210301	Гэрэл, цахилгаан	3,512,462.00	5,629,937.00
210302	Түлш, халаалт	7,442,500.00	15,009,100.00
210303	Цэвэр, бохир ус	137,700.00	148,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,810,920.00	15,073,180.00
210401	Бичиг хэрэг	1,826,072.00	2,642,410.00
210402	Тээвэр, шатахуун	7,852,000.00	7,850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	886,500.00	2,441,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,100.00	114,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,146,248.00	1,923,860.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	100,960.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	105,800,712.18	19,292,619.68
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,800,712.18	19,292,619.68
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,010,000.00	488,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,010,000.00	-
210604	Урсгал засвар	-	488,700.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	7,415,800.00	8,420,000.00
210702	Дотоод албан томилот	7,415,800.00	8,420,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,628,370.00	2,933,270.00

**Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	785,370.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	479,700.00	303,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	484,300.00	129,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,600.00	38,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	744,790.00	739,500.00
210807	Газрын төлбөр	376,980.00	137,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,513,594.15</b>	<b>79,914,927.91</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,513,594.15	79,914,927.91
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>115,745,500.96</b>	<b>15,252,537.44</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>115,745,500.96</b>	<b>15,252,537.44</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>700,091,600.00</b>	<b>795,989,169.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,003,469.00
120009	Бусад орлого	-	1,003,469.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,091,600.00</b>	<b>793,845,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>700,091,600.00</b>	<b>793,845,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	700,091,600.00	793,845,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>1,140,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,140,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>700,091,600.00</b>	<b>795,989,169.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>700,091,600.00</b>	<b>795,989,169.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>704,091,596.00</b>	<b>795,989,169.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>552,786,627.25</b>	<b>634,369,764.98</b>
210101	Үндсэн цалин	331,487,850.73	339,821,274.80
210102	Нэмэгдэл	146,647,958.27	221,137,937.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,806,659.65	28,962,000.00
210104	Урамшуулал	42,844,158.60	44,448,552.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,843,400.00</b>	<b>83,138,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,868,800.00	54,668,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,197,200.00	6,432,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,274,900.00	6,221,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,776,000.00	3,136,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,726,500.00	12,679,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,637,262.00</b>	<b>13,336,937.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,512,462.00	5,629,937.00
210302	Түлш, халаалт	8,987,100.00	7,559,000.00
210303	Цэвэр, бохир ус	137,700.00	148,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,511,700.00</b>	<b>20,598,490.00</b>
210401	Бичиг хэрэг	1,787,400.00	2,099,040.00
210402	Тээвэр, шатахуун	11,310,000.00	15,511,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	886,500.00	2,441,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,600.00	341,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	229,200.00	205,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,269,200.00</b>	<b>23,350,572.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,403,900.00	22,575,172.20

**Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	865,300.00	775,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,303,036.75	11,123,704.82
210601	Багаж, техник, хэрэгсэл	183,300.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,584,236.75	10,514,704.82
210604	Урсгал засвар	1,535,500.00	609,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,415,800.00	8,420,000.00
210702	Дотоод албан томилолт	7,415,800.00	8,420,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,324,570.00	1,651,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	196,200.00	176,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	479,700.00	430,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	484,300.00	129,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,600.00	38,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	744,790.00	739,500.00
210807	Газрын төлбөр	376,980.00	137,900.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,999,996.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,999,996.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,999,996.00</b>	<b>-</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,999,996.00	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	240,575,168.00	1,965,130.25	358,981,112.71	601,521,410.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>240,575,168.00</b>	<b>1,965,130.25</b>	<b>358,981,112.71</b>	601,521,410.96
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>240,575,168.00</b>	<b>1,965,130.25</b>	<b>358,981,112.71</b>	601,521,410.96
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	<b>240,575,168.00</b>	<b>1,965,130.25</b>	<b>358,981,112.71</b>	601,521,410.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>240,575,168.00</b>	<b>1,965,130.25</b>	<b>358,981,112.71</b>	601,521,410.96
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	15,252,537.44	15,252,537.44
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>240,575,168.00</b>	<b>1,965,130.25</b>	<b>374,233,650.15</b>	616,773,948.40

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7

**Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	634,373,100.00	635,373,233.98	(1,000,133.98)	(0.2)
210101	Үндсэн цалин	342,166,000.00	340,824,743.80	1,341,256.20	0.4
210102	Нэмэгдэл	221,142,500.00	221,137,937.98	4,562.02	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,450,300.00	28,962,000.00	488,300.00	1.7
210104	Урамшуулал	41,614,300.00	44,448,552.20	(2,834,252.20)	(6.8)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,679,800.00	83,138,000.00	3,541,800.00	4.1
210201	Тэтгэврийн даатгал	54,759,900.00	54,668,800.00	91,100.00	0.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,442,300.00	6,432,400.00	9,900.00	0.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,603,400.00	6,221,000.00	3,382,400.00	35.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,169,400.00	3,136,600.00	32,800.00	1.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,704,800.00	12,679,200.00	25,600.00	0.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,552,600.00	13,336,937.00	215,663.00	1.6
210301	Гэрэл, цахилгаан	5,841,000.00	5,629,937.00	211,063.00	3.6
210302	Түлш, халаалт	7,563,400.00	7,559,000.00	4,400.00	0.1
210303	Цэвэр, бохир ус	148,200.00	148,000.00	200.00	0.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,060,700.00	20,058,490.00	2,210.00	0.0
210401	Бичиг хэрэг	2,100,000.00	2,099,040.00	960.00	0.0
210402	Тээвэр, шатахуун	14,971,400.00	14,971,000.00	400.00	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.00	2,441,950.00	50.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	341,500.00	341,000.00	500.00	0.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205,800.00	205,500.00	300.00	0.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,570,900.00	23,350,572.20	220,327.80	0.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,794,800.00	22,575,172.20	219,627.80	1.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	776,100.00	775,400.00	700.00	0.1
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,403,800.00	2,586,030.82	2,817,769.18	52.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,794,800.00	1,977,030.82	2,817,769.18	58.8
210604	Урсгал засвар	609,000.00	609,000.00	-	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,500,000.00	8,420,000.00	80,000.00	0.9
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	8,420,000.00	80,000.00	0.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,704,800.00	1,651,700.00	53,100.00	3.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	176,600.00	176,600.00	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	430,300.00	430,300.00	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,300.00	129,300.00	-	-

**Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,100.00	38,100.00	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	739,500.00	739,500.00	-	-
210807	Газрын төлбөр	137,900.00	137,900.00	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	53,100.00	-	53,100.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	793,845,700.00	787,914,964.00	5,930,736.00	0.7
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22	22		
620001	Удирдах ажилтан	01	01		
620002	Гүйцэтгэх ажилтан	17	16		
620003	Үйлчлэх ажилтан	04	05		

**2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>540,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>540,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	540,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	540,000.00
210402	Тээвэр, шатахуун	540,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	540,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	540,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	540,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 207,621.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд 196,233.4 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

- ✓ *Үр дүнгийн тайланд төвлөрүүлсэн орлого, санхүүжилт илүү тусгасан 92,272.5 мянган төгрөгийг залруулсан,*
- ✓ *Мөнгөн хөрөнгийн тайланд төвлөрүүлсэн орлого, санхүүжилт илүү тусгасан 91,269.1 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн тайланд залруулсан,*
- ✓ *Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй 12,691.8 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тус тус 2026.01.25-ны 05 тоот албан бичгээр залруулсан*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар залруулагдаагүй 11,387.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 11,387.7 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 8,813.7 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

## **5.1 Төлбөрийн акт**

### **5.1.1 Цалингийн зардалтай холбоотой**

*Илрүүлэлт: Ажилчидын цалингаас суутгасан цалингийн ашгийн татварыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 8,070.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлэх*

## **5.2 Албан шаардлага**

### **5.2.1 НББ, тайлагналтай холбоотой**

*Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, хөрөнгөө ангилан бүртгээгүй зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин давтан гаргахгүй байх, стандартын дагуу хөрөнгөө ангилан бүртгэх, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ*

### **5.2.2 Авлага, өглөгтэй холбоотой**

*Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийг 3,371.1 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн, өглөг авлагын тооцоо нийлж үлдээдлийг батагаажуулаагүй, цалингийн тооцооллыг үнэн зөв хийгээгүй зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нээж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Шийдвэрлэсэн нь: Ажилчидад олгосон цалингийн тооцооллыг үнэн зөв хийж өглөг авлагыг баталгаажуулах*

### **5.3 Зөвлөмж**

#### **5.3.1 Эм, боох материалын худалдан авах ажиллагаатай холбоотой**

*Илрүүлэлт: Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм, эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эм, боох материалын өндөр дүнтэй үлдэгдэлтэй байгаа зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж дотоод хяналтыг сайжруулах*

#### **5.3.2 НББ, тайлагналтай холбоотой**

*Илрүүлэлт: НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материал болон бусад материалыг зөв ангиалан бүртгээгүй зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллогыг чанартай хэрэгжүүлэх, НББ-ийн ОУ-ын стандартын дагуу бараа материалыг ангиалан бүртгэх*

*Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.*

*Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.*

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Зооноз ӨСТ	Үр дүнгийн тайланд орлого үнэн зөв илэрхийлээгүй	1	92,272.5			1	92,272.5				
	Мөнгөн хөрөнгийн тайланд орлого үнэн зөв тайлагнаагүй	1	91,269.1			1	91,269.1				
	Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр дүнгээр тайлагнаагүй	1	12,151.8			1	12,151.8				
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>195,693.4</b>	-	-	<b>3</b>	<b>195,693.4</b>	-	-		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Зооноз ӨСТ	Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2026 оны 01/103 тоотын дагуу цажим дэлгүүрээс эм, эмийн хэрэгсэл болон бусад материал хөрөнгө худалдан аваагүй	1	-						1	-		
	Нийгмийн даатгалын газарт нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн	1	3,317.1			1	3,317.1					
	Цалингаас суутгасан ашгийн татварыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй	1	8,070.6	1	8,070.6							
	НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын болон бусад материалыг зөв ангилан бүртгээгүй	1	-						1	-		
	Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн дахин үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалын акт үйлдээгүй, хөрөнгийн ангилан бүртгэлт хийгээгүй	1	-				1	-	-	-		
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>11,387.7</b>	<b>1</b>	<b>8,070.6</b>	<b>2</b>	<b>3,317.1</b>	<b>2</b>	<b>-</b>			